



## ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/397

Хэрлэн сум

### Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу Монами мийт (РД:6197361)-ын эзэмшлийн Хэрлэн сумын 3 дугаар баг Залуучуудын Д-13 тоот хаягтай Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалттай 1225м<sup>2</sup> газрыг Мөнх-Эрдэнэ Энхтүвшин (РД:СЕ79092507)-д холбогдох бичиг баримтыг үндэслэн газар эзэмших эрхийг шилжүүлсүгэй.

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан иргэдэд газар эзэмших эрхийн гэрчилгээг олгож, гэрээ байгуулан биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Б.Сүнгээ)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбоотойгоор Засаг даргын 2018 оны А/240 тоот захирамжийн дээрх аж ахуй нэгж байгууллагад холбогдох заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Газар эзэмших эрхийн гэрчилгээг  
бусдад шилжүүлэх нэрсийн жагсаалт

2024 оны 07 дугаар сарын 27-ны  
127 дугаар захирамжийн хавсралт

Аймгийн Засаг даргын



д/д	Шилжүүлсэн ААНБ, иргэн, эцэг/эх-ийн нэр	Газрын зориулалт	Газрын хэмжээ /м2/	Эзэмшил газрын байршил	Шилжүүлэн авсан иргэн ААНБ-ын нэр	Хугацаа	Шилжүүлэх үндэслэл
1	Монами мийт /6197361/	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	1225	3-р баг, Заглуучууд Д-13 тоот	Мөнх-Эрдэнэ Энхтүвшин /СЕТ79092507/	52	Хэнтий аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 06 дугаар сарын 12-ны 127 дугаар шүүгчийн захирамж